

## ГЭРЭЭТ ХИЛЧДИЙН СЭТГЭЛ ЗҮЙ ТЭДНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНД НӨЛӨӨЛӨХ НЬ

### ВЛИЯНИЕ ПСИХОЛОГИЧЕСКОГО СОСТОЯНИЯ ПОГРАНИЧНИКОВ-КОНТРАКТНИКОВ НА ИХ ДЕЯТЕЛЬНОСТЬ

### PSYCHOLOGICAL IMPACT OF BORDER TROOPS-CONTRACTORS ON THEIR ACTIVITIES



#### О.НЭМЭХХАНД

ХСИС-ийн Хилийн сургуулийн Цэргийн сэтгэл зүйн тэнхимийн эрхлэгч, гүн ухааны доктор (Ph.D), профессор, дэд хурандаа

#### О.НЭМЭХХАНД

Заведующая, кафедрой Военной психологии, Пограничного института, Университета Правоохранительной службы, доктор (Ph.D), профессор

#### НЕМЕКННАНД О.

The head of Department of military psychology, Border institute, Law Enforcement University, doctor (Ph.D), professor, lieutenant colonel

**Товч утга:** Энэхүү илтгэлд “Сэтгэл судлал нь хүнийг танин мэдэхдээ сэтгэц, түүний илрэлүүдээр дамжуулан судалдаг” гэсэн онолыг үндэслэл болгож, Төв аймгийн Баянчандмань дахь Хил хамгаалах албаны тусгай бэлтгэлийн цогцолборт зохион байгуулсан “Гэрээт хилчин”-ий анхан шатны сургалтад удаа дараа оролцож сургалт зохион байгуулж байсан, Хууль сахиулахын их сургуулийн Хилийн сургуульд “Гэрээт хилчид”-ээс албыг амжилттай хааж, “Хилийн албаны ажилтан-офицер” мэргэжлээр суралцаж буй сонгогчдод хичээл зааж байх явцад авсан судалгааны дүнг тус тус үндэслэл болгож бичив.

**Abstract:** The individual psyche in terms of its manifestation is divers. Mental states characterize the human psyche as a whole. Mental states influence the course and results of mental processes, and can air or inhabit the activities of the individual. The independence of thought is manifested above all in the ability to see and pose a new question, to scientifically establish a problem, and then to solve the problem with one's abilities. The purposefulness of thought means the ability to concentrate thought on a delimit goal, without being distracted and without stopping the search for the right solution. Breath of thought provides an opportunity to note and constantly keep under his control a large number of relations between objects and phenomena. A flexibility thinking person is able to disclose contractions in phenomena, and is decision. Rapidly of thought is particularly essential in those instances when it is necessary to make correct and sound decisions in a very short time. Profoundly thinking person not only understands events, but also foresees their development.

**Аннотация:** Психика человека по своим проявлениям многообразна. Психические состояния характеризуют психику человека в целом. Психические состояния влияют на течение и результаты процессов и могут способствовать или тормозить активную деятельность личности. Самостоятельность мышления проявляется прежде всего в умении увидеть и поставить новый вопрос, научно обосновать проблему и затем решить их своими силами. Целеустремленность мышления означает способность концентрировать мысль на определенной цели, не отвлекаясь и не прекращая поиска правильного решения. Широта мышления дает возможность заметить и постоянно держать под своим контролем большое количество связей между предметами и явлениями. Обладающий гибким умом “пограничник-контрактник” способен вскрывать противоречия в явлениях, умеет своевременно подмечать изменения в обстановке, вносить поправки в принятое ранее решение. Быстрота мысли особенно нужна в тех случаях, когда необходимо принимать правильные, обоснованные решения в очень проткий срок. Глубокомыслящий “пограничник-контрактник” не только понимает события, но и предвидит их развитие.

**Түлхүүр үгс:** Гэрээт хилчин, сэтгэл гутрал, сэтгэл түгших, нойрны хямрал, сэтгэхүйн хямралууд.  
**Key words:** Border troops-contractors, psychological depression, insomnia, mental stresses.

Дэлхийн олон улс орнууд (АНУ, Англи, Белги, Дани, Франци, Голланд, Австри, ОХУ, БНХАУ) гэрээт цэргийн албыг улсын хил хамгаалалтад нэвтрүүлж, өөр өөрсдийн эдийн засгийн боломж, техник технологийн чадамж, физик газар зүйн онцлог, хил хамгаалалтын нөхцөл байдалдаа тохируулан ашиглаж эхэлснээр үр дүнгээ өгсөөр байна.<sup>1</sup> Манай улсын хувьд гэрээт хилчдийн албыг нэвтрүүлэхэд ач холбогдол өгч алба, үйл ажиллагаанд ашигласнаар бие бүрэлдэхүүнийг мэргэжлийн жишигт хүргэх, сургаж дадлагажуулах, улсын хил хамгаалалтын найдвартай байдал хангагдах үндэс нь болж байгаа нь харагдаж байна.

Гэрээт хилчдийн алба, үйл ажиллагаанд нөлөөлөх хүчин зүйлсийн тоонд анхаарал татсан асуудлуудын нэг нь тэдний ухамсар, сэтгэл зүйн нөлөөлөл байдаг. Энэ нь юуны өмнө цэргийн албанд сэтгэхүйн хямралаар илрэх бөгөөд “гэрээт хилчид”-ийн сэтгэхүйн хямралын үүсэх шалтгаан нь хугацаат цэргийн албан хаагчдыг бодвол харьцангуй ялгаатай төдийгүй энэхүү сэтгэхүйн хямралаас сэргийлэх арга замыг оновчтой зөв тодорхойлох явдал “Гэрээт хилчдийн албыг боловсронгуй болгоход” зүй ёсоор тавигдаж байгаа юм.

Хүний сэтгэл санааны байдлаас шалтгаалан эерэг, сөрөг нөлөө үзүүлж, улмаар хүний нийгэм биологийн хэрэгцээ хангагдаагүйгээс бие махбодь физиологийн хамгаалах урвал болох “хүчдэлийн байдал”-д орохыг стресс гэнэ. Айх, сэтгэл түгших, бухимдах, сэтгэлээр гутрах, уурлах зэрэг сэтгэл зүйн гаралтай стрессийг сэтгэлийн стрессор гэнэ.

Цэргийн албан хаагчид алба, үйл ажиллагааныхаа явцад тодорхой хэмжээгээр стресстэй учирч байдаг хэдий ч стресс бүхэн хүнд сэтгэлийн шалтгаант сэтгэцийн болон зан үйлийн эмгэгийг үүсгэдэггүй. Үүнийг тухайн стрессорын шинж чанар, хүч, үргэлжлэх хугацаа болон бие хүний мэдрэл шингэний дотоод зохицуулалт, бие эрхтэний үйл ажиллагаанд нөлөөлж, тухайн нөхцөлд болж буй үйл явдал, орчин, амьдралд дасан зохицож байгаагийн илрэл хэмээн Ганс-Сельегийн (1925) дасал зохицлын онолоор тайлбарлаж болох юм.

Сэтгэхүйн хямрал үүсэх шалтгаан, нөхцөл нь Хугацаат цэргийн албан хаагчид болон Гэрээт хилчдэд өөр өөр байдлаар илэрдэг нь нэгэнт тодорхой болжээ. Тухайлбал: “Гэрээт хилчин”-ий анхан шатны сургалтын төвд “Гэрээт хилчин гэрэлтэй алба”-ыг сурталчилж, тухайн гэрээт хилчдийн алба хаах ангийн болон хилийн заставын онцлог, цаг агаар газар зүйн онцлог, ахуй нөхцлүүдийг нь үнэн бодит байдлаар таниулаагүйн улмаас сэтгэлийн хөөрлөөр “гэрээ байгуулах”, томилогдож очсон анги, байгууллагаа голж, албанаас бэрхшээн шантрах, ар гэрийн гачигдал, чөлөө авах, амралт эдлэх нэрийдлээр алба хаяж явах улмаар албыг цалгардуулахад хүргэдэг. Энэ байдал нь тухайн “гэрээт хилчин”-д зонхилон тохиолддог сэтгэцийн болон зан үйлийн дараах эмгэгүүдээр илэрдэг байна. Үүнд:

- Сэтгэл гутрал: (гунигт автах, юм хийх идэвхи сонирхолгүй, нойр муудна, үг яриа, хөдөлгөөн удааширна, өтгөн хатна, амиа хорлох хорлох бодол төрөх, бодлогоширонгүй, ганцаараа уйлж суудаг, заримдаа эрс уурлаж догширох, бухимдаж түгших байдал илрэнэ.)

- Сэтгэл түгших: (дарга, удирдах ажилтныг дуудахад, шинэ хамт олны дунд ороход, яах бол? гэж түгших, зүр дэлсэх, чичрэх, ойр ойрхон шээс хүрэх, хүйтэн хөлс гарах нь хэвийн сэтгэл түгшилт боловч, энгийн ялгүй зүйлд байн байн түгших, хар аяндаа сэтгэл хий юманд зовних нь сэтгэл түгших эмгэг юм.)

<sup>1</sup> Ц.Батбаяр. Улсын хил хамгаалалтад гэрээт цэргийг оролцуулах зарим асуудал. (Магистрын зэрэг горилсон судалгааны ажил). УБ. 2008, 32 дахь тал

- Архи, тамхи хэтрүүлэн хэрэглэх:
- Нойрны хямралууд: (нойрон дундаа босч явах, нойр хулжих, нойрондоо чанга ярьж шүдээ хавирах)
- Архаг ядаргаа: (невроастени)
- Тайлбарлашгүй бие махбодын зовиур шаналгаанууд: (ууц нуруугаар нь өвдөнө, хоолой дээр нь юм тээглэнэ, бөөлжис хүрнэ, биеэр нь юм туурна, толгой өвдөнө гэх мэт хэд хэдэн зовиур тоочих боловч зовиур нь тодорхой шинж чанар, байрлалгүй, нарийн мэргэжлийн эмчид үзүүлж зөвлөгөө авах боловч бодит өөрчлөлт илрэхгүй байх, түүний хэлж буй шаналгаа нь стрессийн улмаас үүссэн талаар ойлголцогүй байдаг. Өөрөөр хэлбэл, энэ бол өвчин биш, сэтгэл санааны тааламжгүй шалтгааны улмаас илэрч буй зовиур юм.)

Сэтгэхүйн хямралыг 3 түвшинд авч үзэж болох юм.

1. Эхэн үеийн сэтгэхүйн хямрал: Хугацаат цэргийн албан хаагчдын хувьд цэргийн албанд татагдан орж, эрх зүйн тодорхой хязгааралттай орчин, нарийн цагийн хуваарьт өдөр тутмын үйл ажиллагаа, захирагч дарга нарын албадлагын харьцаа, нормт хоол хүнс, хувцасны хангалт, өссөн төрсөн газар орноосоо алслагдсан, ойр дотны хүмүүсээс холдсон, амьдралын хэвшлийн гэнэтийн өөрчлөлт зэрэг хүчин зүйлс нөлөөлдөг. Гэтэл "гэрээт хилчид" урьд нь цэргийн алба хаасан байдаг учир дээрх шалтгаанаар сэтгэхүйн хямрал үүсэхгүй, харин ч цагийн хуваарьт өдөр тутмын үйл ажиллагаа алдагдсанаас, түүнчлэн захирагч дарга нарын албадлагын харьцаа үүссэнээс, ар гэрийн байдалд санаа зовних, өсвөр насны залуучуудын хувд нөхөн үржихүйн физиологи шаардлага зэрэг нь тэдний сэтгэхүйн хямралыг үүсгэх нөхцлийг бүрдүүлдэг байна.

2. Дунд түвшний сэтгэхүйн хямрал: албаны карьераа өсгөх бололцоо муу, бусдад атаархах, архи согтууруулах ундаанд дурлах зэрэг хувь хүний өөрийн ахуйн болон амьдралын зөрчилд суурилж, алба хаах хүсэл эрмэлзлэл нь буурсан байдаг. Энэ үеийн сэтгэхүйн хямралын нэг онцлог нь гэрээт хилчинд сэтгэлийн байнгын хариу нэхсэн зовиурын байдлаар мэдрэгдэж түүнд үзүүлэх эсэргүүцлийн сэдлийн чадавх сул тул ажил албандаа хайнга хандах, тодорхой шалтгаангүй уйтгар гунигт автах, царай зүс дарах зэрэг байдлаар илэрч, энэ байдлаа бусдад нялзаах оролдлого хийх нь элбэг.

3. Дээд төвшний сэтгэхүйн хямрал нь: Энэ түвшний сэтгэхүйн хямрал нь дээд мэдрэлийн үйл ажиллагаа гэнэтийн хүчтэй сөрөг нөлөөлөл, мэдээлэл, цочролтой тулгарсаны үр дүнд үүсдэг бөгөөд үргэлжлэх хугацаа, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг шинжээрээ сэтгэцийн өвчин эмгэгт ч хүргэж болох аюултай шинжийг агуулдаг. Иймд айдас, түгшүүрт өртөх магадлал өндөртэй хүмүүсийг урьдчилан тогтоож тэдэнд учирч болзошгүй аюул заналыг даван гарах талаар сэтгэл зүйн зөвлөмж өгөх асуудал зайлшгүй чухал юм.

Гэрээт хилчний албанд ирээд 3-аас дээш сар болоод сэтгэцийн хямралын дараах шинж ажиглагдаж байгаа эсэхэд анхаарч хэрэв илэрвэл даруй хилийн заставын орлогч, хилийн отряд (анги)-уудын гэрээт хилчин хариуцсан ажилтан нарт мэдэгдэж, тухайн гэрээт хилчинд хяналт тавьж, албандаа чин сэтгэлээсээ хандаж байгаа эсэх, гэрээт хилчний алба хаах сонирхол нэмэгдэж байгаа эсэхэд анхаарч, улмаар гэрээт хилчдэд амралт, чөлөөг "журам" баримтлан олгож, ирэх, явах үед нь тодорхой үүрэг чиглэлээр хангаж ажиллах нь үр дүнтэй ажээ.

Сэтгэцийн хямралын илрэх шинж: нүдээ ойрхон цавчлах, мөрөө ойр ойрхон хавчих, шөнө босч явах, хүний сонирхол татмааргүй зүйлсийг сонирхон цуглуулдаг

болох, ямар нэгэн шинжлэх ухааныг гэнэт шимтэн сонирхох, өөрийн нүүр царайны өчүүхэн согогийг хэтрүүлэн үнэлэж царай зүс, бие бялдрын байдлаа чамлан голох, орондоо шээх, бэлгийн дур хүслээ зүй бусаар хангах байдал ажиглагдах, сэтгэлийн нарийн мэдрэмжгүй нэгэн хэвийн хүйтэн хөндий, хайхрамжгүй байдлаар хандах, хувийн ариун цэвэрт анхаарахгүй бохир заваан болох, хэвийн биш бодол санаа итгэл үнэмшилтэй болох, хэл яриа нь этгээд хачин ойлгомжгүй болох улмаар мэдрэхүйн хүрээнд өөрчлөлт ордог.

Гэрээт хилчдийг сэтгэл зүйн хямралаас хамгаалах асуудал нь сэтгэл зүйн бэлтгэлийн үндсэн зорилт юм. Сэтгэл зүйн бэлтгэл нь сэтгэл зүйн тогтвортой байдлын эхлэл бөгөөд өөрөөр хэлбэл, сэтгэл санаа тогтвортой байснаар л алба, үйл ажиллагаа хэвийн явагдана. Харин гэрээт хилчдийн сэтгэл санааны тогтворгүй байдал нь удирдлага, дарга нартаа итгэл алдрахаас эхэлдэг. Иймд гэрээт цэргийн алба хаагчидтай шилдэг офицер, ахлагч нарыг ажиллуулж, гэрээт хилчин нэг бүрийн зан ааш, авир араншин, темперамент, ар гэрийн байдал, удамшлын байдал (архинд донтох өвчтэй хүн байсан эсэх, амиа хорлох оролдлого хийж байсан буюу амиа хорлосон хүн байгаа эсэх, гадуур тэнэдэг, хулгай хийх, мөрийтэй тоглох болон бусад эмгэг донтой хүн байсан эсэх, этгээд араншинтай, догшин ширүүн зантай хүн байсан эсэх)-д нь судалгаа хийж ажиглах, гэрээт хилчдийн ажлын ачаалал даах чадварт хяналт тавьж, ажил амралтыг нь зөв зохицуулах, хэдийгээр гэрээт хилчид мэргэжилдээ дур сонирхолтой, албандаа амжилт үзүүлдэг боловч, гэрээт хилчний албаны үнэ цэнэ, мэргэжлийн баримжаа олгох ажил дутмаг явагдсанаас стресс үүсч, улмаар сэтгэцийн эмгэгт хүрч болзошгүй гэдгийг анхаарч ажиллах шаардлагатай байна. Иймд гэрээт хилчдийн сонгон шалгаруулалтад эрүүл мэнд, бие бялдарын үзүүлэлтээс гадна сэтгэл зүйн (ёс суртахуун, хүсэл сонирхол, оюун ухааны чадамж, зан чанар, амьдарлын зуршил, сэтгэхүйн удамшлын байдал) онцлогийг судлах шаардлагатай. Харин гэрээт хилчний албанд шалгараад үүргээ гүйцэтгэж байгаа нөхцөлд соёл, сурталчилгаа, олон нийтийн ажлыг (ахмад хилчид, эмэгтэйчүүд, гэр бүлийн ойр дотны хүнтэй нь хамтран) зохион байгуулж, цэргийн албан хаагчдын хоорондын дүрэмч харилцааг чанд хэрэгжүүлж, мэргэжлийн ур чадвараар бусдыг манлайлах, бүтээлч сэтгэлгээг нь хөгжүүлэх, урам зоригийг нэмэгдүүлэх ажил зохион байгуулах нь үр дүнтэй хэмээн дүгнэн үзэж байна.

#### **Эх сурвалжийн жагсаалт.**

1. Батсайхан Б., Дэлгэржав М. Ерөнхий сэтгэл судлал. УБ., Соёмбо принтинг, 2013.
2. Жовдон Ц., Энхболд С. Сэтгэл судлал. УБ., Өнгөт хэвлэл, 2002.
3. Батбаяр Ц. Улсын хил хамгаалалтад гэрээт цэргийг оролцуулах зарим асуудал. (Магистрын зэрэг горилсон судалгааны ажил). УБ. 2008.
4. Нямаа Ж. Сэтгэл судлалын шинжлэх ухааны нэр томъёоны англи-монгол толь. УБ., Согоо нуур, 2006, 196 хууд.
5. Хишигсүрэн . Сэтгэцийн эрүүл мэндийн анхны тусламжийн зарим тулгамдсан асуудлууд. УБ., 2000, 101 хууд.